МОНГОЛ УЛС
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2018 оны 11 сарын 28 өдөр Дугаар А/520 Мандалговь

Бичил уурхай эрхлэгчдээс
жонш худалдан авах аж ахуйн нэгж
сонгох тухай

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 70 дугаар тогтоолоор баталсан "Бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулах журам"-ын 5.1 дэх заалт, "Ажлын хэсэг томилох тухай" аймгийн Засаг даргын 2018.09.05-ны А/369 дугаар захирамжийн 2 дахь заалт, уг захирамжаар томилогдсон ажлын хэсгийн 2018 оны 11дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Луус сумын бичил уурхай эрхлэгчдээс жонш худалдан авах аж ахуйн нэгжээр "Тавин Эх" ХХК, "Ембүүт хэрлэн энергео" ХХК, "Майн Ланд майнинг" ХХК-уудыг сонгон шалгаруулж ажиллуулсугай.

Хоёр. Сумын Засаг дарга, худалдан авалт хийхээр сонгогдсон аж ахуйн нэгж, бичил уурхай эрхлэгчдийн хооронд гурвалсан гэрээ байгуулж ажиллахыг Луус сумын Засаг дарга (Л.Цогзолмаа), бичил уурхай эрхлэгч нөхөрлөлийн ахлагч, аж ахуйн нэгжийн захирлуудад тус тус үүрэг болгосугай.

Гурав. Бичил уурхайн болон худалдан авалтын үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаад байнгын хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн Хяналтын Газар (Ш.Төрбат), Луус сумын Засаг дарга (Л.Цогзолмаа), холбогдох хууль, хяналт, мэргэжлийн байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ

488010605